



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 16 өдөр

Дугаар А/202

Сүхбаатар сум

### Ажлын хэсэг байгуулах, хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 "а", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалт, Сангийн сайдын 2015 оны "Журам шинэчлэн батлах тухай" 341 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, Сэлэнгэ аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн болон хувийн хэвшлийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагуудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар, Сангийн яамнаас баримталж буй бодлого чиглэлийг үндэслэн Сэлэнгэ аймгийн Төрийн сангийн бодлогын бичиг баримтыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг гуравдугаар хавсралтаар тус тус байгуулсугай.

2.Бодлогын бичиг баримт боловсруулах ажлын хэсгүүдэд мэргэшил, арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлж, төрийн болон хувийн хэвшлийн, аудитын байгууллагуудаас бодлогын бичиг баримтад тусгах саналыг авч тусган 2020 оны 10 сарын 01-ний дотор бодлогын бичиг баримтын төслийг танилцуулж, батлуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /О.Мөнхбаяр/-т даалгасугай.


3.Бодлогын бичиг баримт боловсруулах ажлын хэсэгт идэвх санаачилгатай ажилласан ахлагч, гишүүдэд шаардлагатай урамшууллын зардалд 2,100,000 /Хоёр сая нэг зуун мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Мөнхбаяр/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

Сэлэнгэ аймгийн Засаг даргын  
2020 оны 07 сарын 16 -ны өдрийн  
А/202 тоот захирамжийн нэгдүгээр хавсралт



ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДАД МӨРДӨХ НЯГТЛАН  
БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ  
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Энхтуяа

- Мандал сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны дарга

Гишүүд:

Ч.Сугардорж

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн хөрөнгө оруулалт хариуцсан нягтлан бодогч

Б.Тэргэл

- Сайхан сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны дарга

А.Төгсжаргал

- Ерөө сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны дарга

Э.Туул

- Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн албаны дарга


Б.Батдэлгэр

- Түшиг сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны дарга

Р.Байгалмаа

- Мандал сумын 12 жилийн 1 дүгээр сургуулийн ахлах нягтлан бодогч

А/202 Сэлэнгэ аймгийн Засаг даргын  
2020 оны 07 сарын 16 -ны өдрийн  
тоот захирамжийн хоёрдугаар хавсралт



ОРОН НУТГИЙН БОЛОН ХУВИЙН ХЭВШЛИЙН БАЙГУУЛЛАГУУДАД  
МӨРДӨХ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ  
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Наранзул

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Санхүү, төрийн сангийн хэлтсийн  
бүртгэлийн мэргэжилтэн

Гишүүд:

Б.Болормаа

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Санхүү, төрийн сангийн хэлтсийн орлогын  
мэргэжилтэн

Г.Баясгалан

- Баянгол сумын Засаг даргын Тамгын  
газрын Санхүүгийн албаны дарга

Д.Отгонтуяа

- Аймгийн Татварын хэлтсийн мэргэжилтэн


Д.Ванчигмаа

- "Сэлэнгэ энерго" ОНӨААТҮГ-ын ерөнхий  
нягтлан бодогч

А.Гэрэлмаа

- "Мэдээлэл аудит" ХХК-ний ерөнхий нягтлан  
бодогч

А/202 Сэлэнгэ аймгийн Засаг даргын  
2020 оны 07 сарын 16 -ны өдрийн  
тоот захирамжийн гуравдугаар хавсралт



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТӨРИЙН САНГИЙН  
БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч:

Х.Мөнхжаргал

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Ерөнхий нягтлан бодогч

Гишүүд:

Б.Болорчимэг

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн

Ж.Хишигдэлгэр

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн мэргэжилтэн

Х.Оюунбилэг

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн

Э.Ганчимэг

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн

Р.Үнэнбат

- Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны дарга

Л.Балжинням

- Баруунбүрэн сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны дарга